

Флатландын сансрын төв

Флатланд улсад n хот m сансрын төв байдаг. Хот бүр хоорондоо яг ижил нэг нэгж зайтай ба сансрын төв аль нэг хот дээр байрлана.

Хотууд 0-ээс эхлэн дараалан дугаарлагдсан.

Таны даалгавар бол хот бүрийн хувьд хамгийн ойрхон сансрын төвийн зайнуудаас хамгийн ихийг нь олох юм.

Оролт

n , m тоо эхний мөрөнд зайгаар тусгаарлагдан өгөгдөнө. $1 \leq m \leq n \leq 10^5$.

Дараагийн мөрөнд m ширхэг сансрын төвүүд аль хотод байгааг илэрхийлэх тоонууд өгөгдөнө.

Гаралт

Бодлогын хариуг шинэ мөрөнд хэвлэ.

Жишээ

Оролт 1


5 2

0 4

Гаралт 1

2

Тайлбар 1



0 хоттой хамгийн ойр сансрын төв 0 зайд байна

1 хоттой хамгийн ойр сансрын төв 1 зайд байна.

2 хоттой хамгийн ойр сансрын төв 2 зайд байна.

3 хоттой хамгийн ойр сансрын төв 1 зайд байна.

4 хоттой хамгийн ойр сансрын төв 0 зайд байна.

Хамгийн их утга нь 2.

Оролт 2

6 6

0 1 2 4 3 5

Гаралт 2

0

Тайлбар 2

$n = m$ тул 0.

Орчуулсан : Дархан-Уул аймгийн Монгол-Оюу сургуулийн 11.1 ангийн сурагч Э.Цэлмэг